



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН ТУШААЛ

2014 оны 12 сарын 05 өдөр

Дугаар 425

Улаанбаатар хот

Төлөвлөгөө батлах тухай


Монгол Улсын Их Хурлын 2014 оны Төрөөс эмийн талаар баримтлах бодлого батлах тухай 57 дугаар тогтоолын 2 дах заалтын 1 дэх хэсгийг үндэслэн ТУШААХ нь:

1. "Төрөөс эмийн талаар баримтлах бодлого"-ыг үе шаттайгаар хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг хавсралтаар баталсугай.

2. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг төрийн нарийн бичгийн дарга /А.Эрдэнэтуяа/-д үүрэг болгосугай.

САЙД

Н.УДВАЛ



D:\barimt\tushaal

082480

Эрүүл мэндийн сайдын 2014 оны
 12 сарын 05 өдрийн 4625 дугаар
 тушаалын хавсралт

Төрөөс эмийн талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэх төлөвлөгөө

No	Хэрэгжүүлэх үйл ажиллагаа	Хугацаа					Гарах үр дүн	Шалгуур үзүүлэлт	Хариуцагч, хамтран ажиллагч байгууллага
		2014	2015	2016	2017	2018			
Нэг. Эмийн чанар, аюулгүй байдлын баталгаа									
Бодлогын чиглэл:								Хүрэх үр дүн:	
1.1. эрүүл мэндийн болон мал эмнэлгийн тусламж, үйлчилгээний хэрэгцээнд нийцүүлэн эмчилгээний өндөр идэвхтэй, чанартай, аюулгүй эмийг Монгол Улсын эмийн бүртгэлд бүртгэх								Монгол улсын хүн ам эмчилгээний идэвхтэй, чанартай, аюулгүй эм хэрэглэнэ.	
1.1.1	Эм, эмнэлгийн хэрэгслийн бүртгэлийн дүрмийг шинэчлэн батлах		+				Эмийн бүртгэлийн үйл ажиллагаа олон улсын жишигт ойртож, эмчилгээний өндөр идэвхтэй, чанартай, аюулгүй эмийг хэрэглэх боломж бүрдэнэ.	Эм, эмнэлгийн хэрэгслийн бүртгэлийн дүрмийг шинэчлэн баталсан байна.	ЭМЯ
1.1.2	Эм зүй, эмнэлзүйн шинжээчдийн чадавхийг сайжруулах		+	+	+	+	Шинжээчдийн бүртгэлийн материалыг үнэлэх чадавхи сайжирч, зөвхөн чанартай, аюулгүй, эмчилгээний идэвхтэй эмийг бүртгэх боломж нэмэгдэнэ.	Шинжээчдэд зориулан жилд 2-с доошгүй удаа сургалт хийж, нийт шинжээчдийн 70% сургалтанд хамрагдсан байна.	ЭМЯ, ЭЗБ, Мэргэжлийн нийгэмлэг холбоод, АШУУИС
1.1.3	Бүртгэлийн гарын авлага боловсруулах		+				Бүртгэлийн үйл ажиллагаанд шаардагдах мэдээллээр хангаж, бүртгэлийг зөв, хяналттай явуулах боломж бүрдэнэ.	Бүртгэлийн гарын авлага гарсан байна.	ЭМЯ

1.1.4	Licemed программы сайжруулж, бүртгэлийн үйл ажиллагааг цахим хэлбэрт шилжүүлж, иргэдэд ил тод болгох		+			Бүртгэлийн үйл ажиллагааны ил тод байдлыг хангаж, бодит мэдээллийг олж авах боломж нэмэгдэнэ.	Licemed программд хандсан хандалтын тоо 2015 онтой харьцуулахад 30% өссөн байна	ЭМЯ, эм үйлдвэрлэгч, импортлогч, бүртгүүлэгч, хэрэглэгч
1.1.5	Эмийн зөвлөлийн гишүүдийг сонгох шалгуурыг боловсронгуй болгох		+			Нотолгоонд суурилан шийдвэр гаргах чадавхтай, ёс зүйтэй гишүүдийг сонгох боломж нэмэгдэж, ашиг сонирхолын зөрчил гаргах боломжийг бууруулна.	Эмийн зөвлөлтийн гишүүдийг сонгох шалгуурыг шинэчлэн тогтоож баталсан байна.	ЭМЯ, ҮХААЯ
Бодлогын чиглэл: 1.2..эмийн чанарыг хянахад эмийн зохицуулалтын чиг үүрэг бүхий байгууллага өөрийн харьяаны эсхүл хараат бус, олон улсын ISO 17025 шаардлага хангасан итгэмжлэгдсэн лаборатороор эмийн чанарыг баталгаажуулах							Хүрэх үр дүн: Эх орны эмийн лабораторийн чадавх нэмэгдэж, эмийн чанар сайжирч, хүн амыг чанартай эмээр хангана.	
1.2.1	Эмийн чанарын хяналтын лабораторид олон улсын ISO/ICE-17025 стандартыг нэвтрүүлэх			+		Эм биобэлдмэлийн лабораторийн үйл ажиллагаа олон улсын түвшинд хүрнэ, чанарын хяналт сайжирна	Эм биобэлдмэлийн нэгээс доошгүй лаборатори ISO/IEC-17025 стандартаар олон улсын түвшинд итгэмжлэгдсэн байна	МХЕГ, Эм биобэлдмэлийн чанарын хяналтын лаборатори
1.2.2	Үндэсний эмийн үйлдвэрүүдийн лабораторийн үйл ажиллагааг үнэлэх			+		Эмийн шинжилгээ явуулах чадавх нэмэгдэж, эмийн чанар сайжирна.	Нийт үйлдвэрийн 50%-д үнэлгээ хийсэн байна	МХЕГ, ЭЗБ, ТББ, СХЗГ
Бодлогын чиглэл: 1.3. эмийн чанарыг хангахад эм үйлдвэрлэгч, ханган нийлүүлэгч, эмийн сан, эмийн зохицуулалтын чиг үүрэг бүхий байгууллага, мэргэжлийн хяналтын байгууллага, чанарын хяналтын лаборатори, эм зүйн болон эрүүл мэндийн мэргэжлийн нийгэмлэг холбоод оролцуулах							Хүрэх үр дүн: Эмийн чанарыг хангахад оролцогч талуудын үүрэг хариуцлага нэмэгдэж, хүн амыг чанартай эмээр хангах боломж нэмэгдэнэ	

1.3.1	Эм зүйн тусламж үйлчилгээний зохистой дадлын стандартуудын мөрдөлтийг хянах		+	+	+	+	Эм зүйн тусламж үйлчилгээг олон улсын түвшинд явуулж, хүн амыг чанартай эмээр хангах нөхцөл бүрдэнэ	Зохистой дадлын мөрдөлтөд 8 удаа хяналт шалгалт хийсэн байна.	МХЕГ, ЭЗБ
1.3.2	Уламжлалт эмийн фармакопейг боловсруулж, мөрдөх			+	+	+	Уламжлалт эмийн чанарын шинжилгээний аргыг боловсронгуй болгосноор уламжлалт эмийн чанар сайжирна	Уламжлалт эмийн фармакопейг боловсруулж, баталж, хэвлүүлсэн байна.	УАШУТҮК, АШУУИС
1.3.3	Эмийн үндэсний фармакопейг шинэчлэн боловсруулж хэвлүүлэх		+	+	+		Эмийн чанарын шинжилгээнд орчин үеийн аргыг хэрэглэх боломж нэмэгдэж, эмийн чанар сайжирна	Үндэсний фармакопей шинэчилж, хэвлэсэн байна.	ЭМЯ, фармакопейн хороо, ЭЗБ
1.3.4	Эмийн чанарыг хангах чиглэлээр оролцогч талуудтай хамтран ажиллах төлөвлөгөө гаргаж, хэрэгжүүлэх		+	+	+	+	Эмийн чанарыг хангахад оролцогч талуудын үүрэг хариуцлага нэмэгдэж, чанартай эмээр хангах боломж нэмэгдэнэ	Эмийн чанарыг хангах чиглэлээр хамтран ажиллах төлөвлөгөөг гаргасан байна. 2018 онд төлөвлөгөөнд туссан ажлын 80-аас доошгүй хувь хэрэгжсэн байна.	ЭМЯ, МХЕГ, ТББ, ЭХБ
1.3.5	Хуурамч эмийн эсрэг стратегийн хэрэгжилтийн төгсгөлийн үнэлгээг хийх			+			Хуурамч эмийн эсрэг стратегийг шинэчлэн боловсруулахад суурь мэдээлэл болно.	Үнэлгээний тайлан гарсан байна	ЭМЯ, ХШУДАГ, АШУУИС
1.3.6	Хуурамч эмийн эсрэг стратегийг шинэчлэн боловсруулах			+	+		Монгол улсын эмийн зах зээл дэх хуурамч эм, стандартын бус эмийн эргэлтээс сэргийлнэ	Хуурамч эмийн стратегийг 2017онд шинэчлэн баталсан байна.	ЭМЯ, АШУУИС

Бодлогын чиглэл:							Хүрэх үр дүн:		
1.4. эмийн үйлдвэр, эм ханган нийлүүлэх байгууллага нь өөрийн бүтээгдэхүүний чанарын баталгааг хариуцах, бүртгэлийн дараах аюулгүй байдлын тандалт судалгааг хийх үүргийг хүлээх, үр дүнг эмийн зохицуулалтын чиг үүрэг бүхий байгууллагад мэдээлэх тогтолцоог хөгжүүлэх							Эмийн чанар, аюулгүй байдал сайжирна		
1.4.1	Фармаковижилансын стратегийг баталж, хэрэгжүүлэх	+	+	+	+	+	Эмийн аюулгүй байдал бэхжинэ, оролцогч талуудын эмийн аюулгүй байдалд хүлээх үүрэг хариуцлага нэмэгдэнэ, иргэдийн эмийн аюулгүй байдлын талаарх мэдлэг, хандлага сайжирна	Фармаковижилансийн үндэсний стратегийн хэрэгжилт 80-аас доошгүй хувьтай байна.	ЭМЯ, ЭЗБ
1.4.2	Эмийн үйлдвэр, эм ханган нийлүүлэх байгууллагад зориулан өөрийн бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хянах гарын авлага боловсруулж, түгээх			+			Эмийн үйлдвэр, ханган нийлүүлэх байгууллага өөрийн бүтээгдэхүүний чанар, аюулгүй байдалд хүлээх хариуцлага нэмэгдэж, зах зээл дэх эмийн чанар, аюулгүй байдал сайжирна	Тусгай зөвшөөрөлтэй эмийн үйлдвэр, эм ханган нийлүүлэх байгууллагуудад гарын авлагыг түгээсэн байна.	ЭМЯ, ЭЗБ, ТББ, ЭХБ
1.4.3	Эмийн гаж нөлөө болон аюулгүй байдлын мэдээллийг бүртгэх, мэдээлэх талаар сургалт зохион байгуулах	+	+	+	+	+	Эмийн гаж нөлөө, аюулгүй байдлын талаарх мэдлэг сайжирч, гаж нөлөөний мэдээлэл нэмэгдэнэ	10 удаа сургалт явуулсан байна. 2018 онд гаж нөлөөг мэдээлсэн байгууллагын тоо 2013 онтой харьцуулахад 30% өссөн байна.	ЭЗБ, Сургагч багш нар, АШУУИС, ЭМХҮТ
1.4.4	Бүртгэлийн дараах тандалт судалгааг хийж эхлэх		+	+	+	+	Бүтээгдэхүүний аюулгүй байдал сайжирч, хүн амыг аюулгүй бүтээгдэхүүнээр хангана	2018 онд тусгай зөвшөөрөлтэй эмийн үйлдвэр, эм ханган нийлүүлэх байгууллагын 70% аюулгүй байдлын тандалт судалгааг явуулах дотоод тогтолцоотой болсон байна.	ЭЗБ, ЭХБ, эм бүртгүүлэгчид, ЭМЯ, ЭЗБ

1.4.5	Бүтээгдэхүүнийг эргүүлэн татах тогтолцоог бүрдүүлэх		+	+			Эмийн үйлдвэр, эм ханган нийлүүлэх байгууллагын өөрийн бүтээгдэхүүний чанар, аюулгүй байдалд хүлээх хариуцлага нэмэгдэж, хүн ам аюултай, чанаргүй бүтээгдэхүүн хэрэглэх эрсдлийг бууруулна	Тусгай зөвшөөрөлтэй эмийн үйлдвэр, эм ханган нийлүүлэх байгууллагын 70% бүтээгдэхүүнийг буцаан татах журмыг боловсруулж баталсан, бүтээгдэхүүнийг буцаан татах механизмыг нэвтрүүлсэн байна.	ЭМЯ, ЭЗБ, ЭХБ, эм бүртгүүлэгчид, мэргэжлийн хяналтын байгууллагууд
Бодлогын чиглэл: 1.5. үндэсний эмийн үйлдвэрийн чанарын баталгааг хангуулж, "Эм үйлдвэрлэлийн зохистой дадал" /GMP/-ын гэрчилгээ олгох								Хүрэх үр дүн: Эмийн үйлдвэрийн үйл ажиллагаа олон улсын түвшинд хүрч, эмийн чанар, аюулгүй байдал сайжирна	
1.5.1	Эм үйлдвэрлэлийн зохистой дадал /GMP/-ын стандартыг шинэчлэн баталж, мөрдөх		+	+	+	+	Эх орны эм үйлдвэрлэл олон улсын түвшинд хүрнэ, эмийн чанар, аюулгүй байдал сайжирна	Эм үйлдвэрлэлийн зохистой дадал /GMP/-ийн стандартыг шинэчлэн баталсан байна.	ЭМЯ, СХЗҮТ
1.5.2	Эм үйлдвэрлэлийн зохистой дадлын сургалтыг институтчилж, сургалтыг тасралтгүй явуулах			+	+	+	Эм үйлдвэрлэлийн зохистой дадлын мэдлэг сайжирч, эмийн үйлдвэрийг эмийн зохистой дадлаар мэргэшсэн хүний нөөцөөр хангана	Эм үйлдвэрлэлийн зохистой дадлыг институтчилж 10-аас доошгүй удаа сургалт явуулсан байна.	ЭМЯ, АШУҮИС,
1.5.3	Эм биобэлдмэлийн байцаагчдыг чадавхжуулж, GMP-ын мэргэшсэн байцаагч бэлтгэх			+	+	+	Эм үйлдвэрлэлийн зохистой дадлын хяналт шалгалт хийх чадавх нэмэгдэж, эмийн үйлдвэр эм үйлдвэрлэлийн зохистой дадлыг хангах боломж нэмэгдэнэ	8-аас доошгүй удаа сургалт явуулж, 5-аас доошгүй мэргэшсэн байцаагч бэлдсэн байна.	МХЕГ, ЭМЯ, ЭЗБ

1.5.4	Эм үйлдвэрлэлийн зохистой дадлын хяналтын хэлтэс (GMP хяналтын хэлтэс) байгуулж, хэлтсийн ажиллах журмыг боловсруулан баталж, хэрэгжүүлэх			+	+		Эмийн үйлдвэрт зохистой дадлын хяналт шалгалт хийх үйл ажиллагаа төлөвшиж, эм үйлдвэрлэлийн зохистой дадлын шаардлага хангасан эмийн үйлдвэр батламж авах боломж бүрдэнэ	Хяналтын хэлтэсийг 2016 онд байгуулж, ажиллах журамыг батлуулсан байна.	ЭМЯ, ЭЗБ, МХЕГ
1.5.5	"Эм үйлдвэрлэлийн зохистой дадал" /GMP/-ын шаардлагад нийцсэн эмийн үйлдвэрт эм үйлдвэрлэх тусгай зөвшөөрлийг олгох		+	+	+	+	Эх орны эм үйлдвэрлэл олон улсын түвшинд хүрнэ, эмийн чанар аюулгүй байдал сайжирна. Монголын эмийн үйлдвэрийг олон улсад хүлээн зөвшөөрөх боломж бүрдэнэ	"Эм үйлдвэрлэлийн зохистой дадал" /GMP/-ын шаардлагад нийцсэн 5-аас доошгүй эмийн үйлдвэр GMP-ын батламж авсан байна.	ЭМЯ, ЭЗБ, эмийн үйлдвэрүүд
Хоёр. Эмийн зохистой хэрэглээ									
Бодлогын чиглэл: 2.1. эмнэлзүйн удирдамжийг нотолгоо, судалгаа, орчин үеийн эмчилгээний технологи, эмнэлгийн тусламжийн тухайн шатлалд нийцүүлэн мэргэжлийн холбооны саналыг харгалзан шинэчлэх, боловсруулж мөрдүүлэх								Хүрэх үр дүн: Эмнэлгийн тусламж үйлчилгээг орчин үеийн түвшинд хүргэх боломж нэмэгдэж, эмнэлгийн тусламжийн үр дүн сайжирна.	
2.1.1.	Эмнэлзүйн заавар шинэчлэн боловсруулах		+	+	+	+	Оношлогоо, эмчилгээг орчин үеийн түвшинд хийх боломж нэмэгдэнэ	Өмнөх хэвлэгдсэн эмнэлзүйн зааврын 50%-ийг 2018 онд шинэчилсэн байх	ЭМЯ, мэргэжлийн зөвлөл, нийгэмлэг, холбоод, АШУУИС
2.1.2.	Шинэчилсэн эмнэлзүйн зааврыг хэвлэн түгээх, цахимд байршуулах			+	+	+	Эмнэлзүйн зааврын хүртээмж нэмэгдэж, оношлогоо, эмчилгээнд мөрдөх боломж нэмэгдэнэ	Шинэчилсэн эмнэлзүйн зааврыг 100% цахимд байршуулсан байна.	ЭМЯ, эрүүл мэндийн байгууллагууд

2.1.3.	Эмийн биоэквивалент чанарыг тооцож эхлэх			+	+	+	Эмийн эмчилгээний идэвх, аюулгүй байдал, чанар нэмэгдэнэ. Хүн ам эмчилгээний идэвхтэй, аюулгүй, чанартай эм хэрэглэх нөхцөл нэмэгдэж, эмийн эмчилгээний үр дүн сайжирна, эдийн засгийн үр ашиг нэмэгдэнэ	Биоэквивалент чанарыг олон сонголтот ерөнхий нэршлийн 5-аас доошгүй эмэн дээр тооцсон байна.	ЭМЯ, эм хангамжийн байгууллага, АШУУИС, ТББ
2.1.4.	Эмийн өртөг-үр дүнг тооцох сургагчдыг бэлтгэж сургалт явуулах		+	+	+	+	Эмийн өртөг-үр дүнг тооцох чадавх бүрдэнэ	10-аас доошгүй сургагчдыг бэлтгэж, 5-аас доошгүй сургалт явуулсан байна.	АШУУИС, ТББ
2.1.5.	Эмийн өртөг-үр дүнг тооцох гарын авлага гаргаж, эмийн өртөг-үр дүнг тооцож хэвших		+	+	+	+	Эмийн өртөг-үр дүнг зөв тооцох боломж нэмэгдэнэ, эмчилгээнд өртөг-үр дүн сайтай эмийг хэрэглэж нөхцөл нэмэгдэж, улсын төсвийг үр ашигтай зарцуулна	Нийт төрийн өмчийн эмнэлгийн 30% нь тооцож хэвшсэн байна.	ЭМЯ, АШУУИС, эмнэлгүүд
2.1.6.	Эмийн өртөг-үр дүнг тооцож буй байдлыг үнэлэх					+	Эмийн өртөг-үр дүнг буруу тооцохоос сэргийлж, зөв тооцох дадал төлөвшөнэ	Үнэлгээний тайлан гарсан байна	ЭМЯ, мэргэжлийн нийгэмлэг, холбоод
Бодлогын чиглэл:								Хүрэх үр дүн:	
2.2. эмнэлзүйн удирдамжийг баримтлан эмнэлгийн тусламж, үйлчилгээний шатлалд нийцүүлэн жор бичих зохистой дадлыг төлөвшүүлэх								Эмийн жор бичилт сайжирна, эмийн зохистой хэрэглээ төлөвшинэ.	
2.2.1.	Эмийн жор бичилтийн стандартыг шинэчлэн батлах, сургалт явуулах	+	+	+	+	+	Эмийн жор бичилт сайжирна, эмийн зохистой хэрэглээ төлөвшинэ. Эмнэлгийн тусламж, үйлчилгээний чанар сайжирна.	Жор бичилтийн стандартыг шинэчлэн баталсан байна. Жор бичилтийн талаар 4 удаа сургалт хийсэн байна.	ЭМЯ, СХЗҮТ, АШУУИС
2.2.2.	Эмнэлзүйн зохистой дадлын стандартыг боловсруулж батлах		+	+			Эмнэлзүйн судалгааг үр дүнтэй, ёс зүйтэй явуулж хэвшинэ	Эмнэлзүйн зохистой дадлын стандартыг боловсруулж баталсан байна.	ЭМЯ, ЭЗБ, СХЗҮТ, АШУУИС

2.2.3.	Жор бичилт, олголтод судалгаа хийх		+				Жор бичилтэд гарч буй алдааг илрүүлж, ЭМД-ыг зохистой ашиглах боломж нэмэгдэнэ	Судалгааны тайлан гарсан байна	ЭМЯ, ЭМДГ, АШУҮИС
2.2.4.	Эмийн жор бичилтийн стандартын хэрэгжилтэд хяналт тавих	+	+	+	+	+	Эмийн зохистой хэрэглээ төлөвшиж, эмнэлгийн тусламж үйлчилгээний чанарт ахиц гарна.	Эмийн жор бичилт, олголт 2014 онтой харьцуулахад 2018 оны эцэст 50% өссөн байна.	ЭЗБ, МХЕГ, аймаг, нийслэлийн МХГ
2.2.5.	Цахим жор нэвтрүүлэх (судалгаа, системийн загварчлал, систем хөгжүүлэлт, туршилт, нэвтрүүлэлт)			+	+	+	Эмийн жор бичилт, олголтод тавих хяналт сайжирч, эмийг жоргүй олгох явдал буурна	Цахим жорын системийн загварыг боловсруулж, 1-с доошгүй эмнэлэгт туршсан байна.	ЭМЯ, МШХХГ, ГЕГ
2.2.6.	Эмийг кодлох (судалгаа, системийн загварчлал, систем хөгжүүлэлт, туршилт, нэвтрүүлэлт) ажлыг нэвтрүүлэх		+	+	+	+	Эмийн бүтээгдэхүүний мөрдөлт сайжирна, хуурамч эмээс урьдчилан сэргийлнэ, бүтээгдэхүүнийг татан авах боломж бүрдэнэ	Эмийн бүртгэлд бүртгэгдсэн эмийн 30%-ийг 2018 онд 2D кодоор кодолсон байна.	ЭМЯ, ЭЗБ, МШХХГ, ГЕГ
2.2.7.	Цахим жор, эмийн бар кодын талаар сургалт явуулах		+	+	+	+	Цахим жор, эмийн бар кодын ашиглалт сайжирна.	4-өөс доошгүй удаа сургалт хийсэн байна.	ЭМЯ, АШУҮИС-ЭЗС, ЭМХҮТ, ХАҮТ
Бодлогын чиглэл:								Хүрэх үр дүн:	
2.3.эмнэлзүйн эм зүйн тусламжийг эмнэлгийн тусламж, үйлчилгээний шатлалд тохируулан үе шаттайгаар хөгжүүлэх								Хэрэглэгчид үзүүлэх эм зүйн тусламжийн чанар сайжирна	
2.3.1.	Эмнэлзүйн эм зүйн тусламжийн өнөөгийн байдлыг үнэлэх		+				Эмнэлзүйн эм зүйн тусламж үйлчилгээний өнөөгийн байдлыг үнэлж, эмнэлзүйн эм зүйн тусламжийг хөгжүүлэх стратеги, төлөвлөгөөг боловсруулахад суурь мэдээлэл болно	Үнэлгээний тайлан гарсан байна	ЭМЯ, эмнэлэг, сургалтын байгууллагууд, ТББ

2.3.2.	Эмнэлзүйн эм зүйн тусламжийг хөгжүүлэх стратеги, төлөвлөгөөг боловсруулж батлах, мөрдөх			+	+	+	Эмнэлзүйн эм зүйн тусламж олон улсын түвшинд ойртоно, эмнэлгийн тусламж сайжирна, улсын төсвийг үр дүнтэй зарцуулна.	Эмнэлзүйн эм зүйн тусламжийг хөгжүүлэх стратеги, төлөвлөгөөг баталсан байна. Төлөвлөсөн хугацааны хэрэгжилт 80-аас доошгүй хувьтай байна.	ЭМЯ, АШУҮИС, МХЕГ, ТББ
2.3.3.	Эмнэлзүйн эм зүйчдийг бэлтгэх, давтан сургах ажлыг эрчимжүүлэх	+	+	+	+	+	Хэрэглэгчид үзүүлэх эм зүйн тусламж сайжирна, эмийн эмчилгээний үр дүн нэмэгдэнэ	5-с доошгүй удаа сургалт явуулж, 70 эмнэлзүйн эм зүйч бэлтгэсэн байна. 100 эмнэлзүйн эм зүйч давтан сургалтанд хамрагдсан байна.	ЭМХҮТ, эмнэлгүүд, АШУҮИС
Бодлогын чиглэл: 2.4. эмнэлэг бүрт эм зүйч, эм зүйн албыг байгуулж, хэвтэн эмчлүүлэгч болон амбулаториор үйлчлүүлэгчдийн эрүүл мэндийн хэрэгцээнд нийцүүлсэн тусламж үйлчилгээг үзүүлэх тогтолцоог бэхжүүлэх								Хүрэх үр дүн: Эмнэлзүйн эм зүйн тусламж үйлчилгээ хөгжинө.	
2.4.1.	Эмнэлэгт эм зүйн алба ажиллуулах эрх зүйн орчныг бүрдүүлэх		+				Эрх зүйн орчин бүрдсэнээр эмнэлэгт эм зүйн алба байгуулах боломжтой болно	Эрх зүйн баримт бичигт эмнэлэгт эм зүйн алба байгуулах тухай тусгаж, батлуулсан байна	ЭМЯ
2.4.2.	Эмнэлэгт эм зүйн алба байгуулж, үйл ажиллагааг тогтмолжуулах		+	+	+	+	Эм зүйн тусламж үйлчилгээг олон улсын түвшинд, чанартай хүргэх боломж бүрдэнэ. Эмийн эмчилгээний алдааг багасгах, түүнээс урьдчилан сэргийлэх боломж нэмэгдэнэ.	2018 онд төрөлжсөн болон үндсэн мэргэжлийн эмнэлгийн 50%-д эм зүйн алба байгуулж, үйл ажиллагаа тогтмолжсон байна.	ЭМЯ, төв эмнэлэг, тусгай мэргэжлийн төв, аймаг, дүүргийн нэгдсэн эмнэлэг

Бодлогын чиглэл: 2.5.эмнэлгийн мэргэжилтэн бэлтгэх болон төгсөлтийн дараах сургалтын хөтөлбөрт Төрөөс эмийн талаар баримтлах бодлого, зайлшгүй шаардлагатай эм, эмнэлзүйн удирдамж, эмийн зохистой хэрэглээ, эмийн гаж нөлөө, хордлогоос сэргийлэх, хэрэглэгчдэд өгөх зөвлөмжийн асуудлыг тусгах							Хүрэх үр дүн: Эмнэлгийн мэргэжилтний чадавх сайжирч, эмнэлгийн тусламжийн чанар сайжирна		
2.5.1.	Эмнэлгийн мэргэжилтэн бэлтгэх болон тасралтгүй сургалтын хэрэгцээг тодорхойлох, сургалтын хөтөлбөрийг үнэлэх			+			Эмнэлгийн мэргэжилтэн бэлтгэх болон тасралтгүй сургалтын хөтөлбөрийг боловсруулахад суурь мэдээлэл болно	Сургалтын хэрэгцээг тодорхойлж үнэлсэн тайлан гарсан байна.	ЭМЯ, ЭЗБ, АШУУИС, ЭМХҮТ
2.5.2.	Эмнэлгийн мэргэжилтэн бэлтгэх хөтөлбөрт эмийн жор бичилт, хууль эрх зүйн зохицуулалт, бодлого, ЗШЭ талаар оруулах			+			Эмнэлгийн мэргэжилтэний эмийн жор бичилт, хууль эрх зүйн зохицуулалт, бодлого, ЗШЭ-ийн мэдлэг сайжирч, эмийн зохистой хэрэглээ төлөвшинө	Эмнэлгийн мэргэжилтэн бэлтгэх хөтөлбөрт эмийн жор бичилт, хууль эрх зүйн зохицуулалт, бодлого, ЗШЭ туссан байна	ЭМЯ, ЭЗБ, сургалтын байгууллага
2.5.3.	Төвөөс алслагдсан аймгуудад мэргэжил дээшлүүлэх бүсчилсэн болон онлайн сургалт явуулах		+	+	+	+	Сургалтын хүртээмж нэмэгдэж, алслагдсан аймгийн эмнэлгийн мэргэжилтний мэдлэг, чадвар, хандлага сайжирна. Алслагдсан аймгийн эмнэлгийн тусламжийн чанар сайжирна	10-аас доошгүй сургалт явуулсан байна.	ЭМХҮТ, ЭЗБ, АШУУИС, ТББ
Бодлогын чиглэл: 2.6. эмийн зохистой хэрэглээний талаар хэрэглэгчийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх							Хүрэх үр дүн: Иргэдийн эрүүл мэндийн боловсрол сайжирч, эмийн зохистой хэрэглээ төлөвшинө		

2.6.1.	Эмнэлэг, эмийн сан үйлчлүүлэгчдэд зориулсан эмийн зохистой хэрэглээний сургалт, мэдээллийг явуулж хэвших	+	+	+	+	+	Иргэдийн эмийн зохистой хэрэглээний мэдлэг сайжирч, зохистой хэрэглээ төлөвшинө	Төрийн өмчийн эмнэлгүүдийн 50% нь жилд 4 удаа сургалт явуулж хэвшсэн байна.	Эрүүл мэндийн байгууллагууд, ЭМХҮТ, ТББ
2.6.2.	Ерөнхий боловсролын сургуульд хэрэгжүүлж буй эмийн зохистой хэрэглээний сургалтын хөтөлбөрийг үнэлж, боловсронгуй болгох					+	Эмийн зохистой хэрэглээний сургалтын хөтөлбөр сайжирч, иргэдийн зохистой хэрэглээний мэдлэг сайжирна	Сургалтын хөтөлбөрийг 2017 онд шинэчилсэн байна.	ЭМЯ, БШУЯ
2.6.3.	Олон нийтийн мэдээллийн хэрэгслээр антибиотикийн зохисгүй хэрэглээ, түүнээс гарах үр дагаврын талаар сэрэмжлүүлэг хүргэх компанит ажлыг зохион байгуулах (net, tv)			+	+	+	Иргэдийн эмийн зохистой хэрэглээний мэдлэг сайжирч, антибиотикийн зохисгүй хэрэглээ, нянгийн тэсвэржилт буурна.	4-өөс доошгүй удаа компанит ажил зохион байгуулсан байна.	ЭМЯ, ТББ, ЭМХҮТ, НЭМҮТ, ШӨХТГ
Бодлогын чиглэл: 2.7.эмийн зохицуулалтын эрх бүхий байгууллагын үнэлж, зөвшөөрсөн мэдээллийг эмнэлгийн мэргэжилтэн, хэрэглэгчид түгээх тогтолцоог бүрдүүлэх								Хүрэх үр дүн: Хэрэглэгчдийг үнэн, зөв, бодит, шинжлэх ухааны үндэстэй, нотолгоонд суурилсан мэдээллээр хангана.	

2.7.1.	Олон нийтийн мэдээллийн хэрэгслээр түгээж буй эмийн мэдээлэл, зар сурталчилгааны бодит байдлыг үнэлэх		+		+	Хүн амд үнэн зөв, тэнцвэртэй, нотолгоотой мэдээлэл, зар сурталчилгааг хүргэх арга хэмжээг төлөвлөхөд суурь мэдээлэл бий болно	2015 болон 2017 онд 2 удаа үнэлгээ хийж, тайлан гарсан байна.	ЭМЯ, ЭЗБ, ТББ, ШӨХТГ, МХЕГ, НМХГ
2.7.2.	Эмийн савлалт, хаяглалтын мэдээллийг үнэлэх			+		Эмийн савлалт, хаяглалтад үнэн зөв, бодит, нотолгоотой мэдээллийг тусгах үйл ажиллагааг сайжруулахад суурь мэдээлэл бий болно	2016 онд үнэлгээний 1 тайлан гарсан байна.	ЭМЯ, ТББ, МХЕГ
2.7.3.	Эмийн хараат бус мэдээллийг цахим хэлбэрээр хүргэх тогтолцоог бүрдүүлэх			+	+	Үнэн зөв, бодит, хараат бус, шинжлэх ухааны үндэслэлтэй, тэнцвэртэй мэдээллийн хүртээмж нэмэгдэнэ	Эмийн хараат бус мэдээллийн цахим сайтыг нээж, үйл ажиллагаа нь тогтмолжсон байна.	ЭМЯ, ЭЗБ, МХЕГ, НМХГ
Бодлогын чиглэл: 2.8.эмийн лавлахыг эмнэлзүйн удирдамжид үндэслэн боловсруулж, эмнэлгийн мэргэжилтэнд түгээх							Хүрэх үр дүн: Эмийн мэдээллийн хүртээмж сайжирна	
2.8.1.	Эмийн лавлахыг шинэчлэн боловсруулах			+	+	Эмнэлгийн тусламж үйлчилгээний чанар сайжирна. Эмийн зохистой хэрэглээ нэмэгдэнэ.	Эмийн лавлахыг 2017 онд шинэчлэн боловсруулсан байна.	ЭМЯ, ТББ, АШУУИС
2.8.2.	Эмийн лавлахыг цахим хэлбэрт шилжүүлэх ажлыг эхлүүлж, хэрэгжүүлэх		+	+	+	Эмийн лавлахын хүртээмж сайжирна	Эмийн лавлахыг цахим хэлбэрээр байршуулж, тогтмол шинэчилсэн байна.	ЭМЯ, ЭЗБ
Бодлогын чиглэл: 2.9.эмийг зах зээлд таниулах үйл ажиллагааг Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын “Эмийг зах зээлд таниулах үйл ажиллагаанд тавих ёс зүйн шалгуур”-т нийцүүлэн хэрэгжүүлэх							Хүрэх үр дүн: Эмийг зах зээлд таниулах үйл ажиллагааг ёс зүйтэй явуулж, эмийн зохистой хэрэглээ сайжирна.	

2.9.1.	Эмийг зах зээлд таниулах үйл ажиллагааны өнөөгийн байдлыг үнэлэх		+			Эмийг зах зээлд таниулах үйл ажиллагааг сайжруулахад суурь мэдээлэл бий болно	Үнэлгээний тайлан 2015 онд гарсан байна.	МХЕГ, НМХГ, ЭМЯ, ЭЗБ, ТББ
2.9.2.	Эмийг зах зээлд таниулах үйл ажиллагааг холбогдох хуулинд тусгах		+			Эмийг зах зээлд таниулах үйл ажиллагааг олон улсын жишгийн дагуу ёс зүйтэй зохион байгуулдаг болно. Эмийн зохистой хэрэглээнд ахиц гарна.	Эмийг зах зээлд таниулах үйл ажиллагааг холбогдох хуулинд тусгасан байна.	ЭМЯ
2.9.3.	Эмийг зах зээлд таниулах үйл ажиллагааны гарын авлагыг боловсруулж, түгээж, хэрэгжилтийг хангах			+	+	Эмийг зах зээлд таниулах үйл ажиллагааг тэнцвэртэй, үнэн зөв, бодит мэдээллийг ашиглан ёс зүйтэй явуулж хэвшинэ	Эмийг зах зээлд таниулах үйл ажиллагаанд ДЭМБ-ын ёс зүйн шалгуурыг тусгасан гарын авлагыг 2017 онд боловсруулж, эрүүл мэндийн байгууллагуудад түгээсэн байна.	ЭМЯ, ЭЗБ, ТББ, ЭХБ, эм бүртгүүлэгчид
Бодлогын чиглэл:							Хүрэх үр дүн:	
2.10.антибиотикийн зохистой хэрэглээг төлөвшүүлэх зорилгоор эмэнд нянгийн тэсвэржилт үүсэхээс сэргийлэх стратегийг хэрэгжүүлэх							Антибиотикийн зохистой хэрэглээ төлөвшиж, антибиотикийн дасал саарна.	
2.10.1	Стратегийн хэрэгжилтийн явцыг үнэлэх, цаашид авах арга хэмжээг тодруулах		+			Стратегийн хэрэгжилтийг хангаж, амжилттай хэрэгжүүлэх нөхцөл бүрдэнэ	Үнэлгээний тайлан 2015 онд гарсан байна	ЭМЯ, ХШҮДАГ, ТББ
2.10.2	Антибиотикийн хангамж, хэрэглээ, жор бичилтийн байдалд судалгаа хийх, өмнөх судалгааны дүнтэй харьцуулах			+		Антибиотикийн хангамж, хэрэглээ, жор бичилтийн суурь мэдээлэл бий болж, гарч буй ахиц дэвшлийг тодруулж, цаашид авах арга хэмжээг төлөвлөхөд суурь болно	Судалгааны тайлан 2016 онд гарсан байна	эмнэлгүүд, АШУҮИС, ТББ

2.10.3	Стратегийн хэрэгжилтийн төгсгөлийн үнэлгээ хийх, мэдээлэх					+	Антибиотикийн даслыг сааруулах арга хэмжээг төлөвлөхөд суурь мэдээлэл бий болно	Стратегийн төгсгөлийн үнэлгээний тайлан 2018 онд гарсан байна	ЭМЯ, ХШУДАГ
Бодлогын чиглэл: 2.11.эрүүл мэндийн болон хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага хөдөө аж ахуйн салбар дахь антибиотик болон бусад эмийн хэрэглээний асуудлаар хамтран зохицуулалтын арга хэмжээ авах								Хүрэх үр дүн: Хүнсний аюулгүй байдал сайжирч, антибиотикийн дасал саарна	
2.11.1	Хөдөө аж ахуйн салбар дахь антибиотикийн хэрэглээний судалгаа хийх			+			Хөдөө аж ахуйд хэрэглэж буй антибиотикийн суурь мэдээлэл бий болж, антибиотикийн хэрэглээг зохицуулахад ашиглана	Судалгааны тайлан 2017 онд гарсан байна.	ҮХААЯ, судалгаа шинжилгээний байгууллага
2.11.2	Хүнсний бүтээгдэхүүнд антибиотик болон бусад эмийн үлдэгдлийг тодорхойлох, хүнсний бүтээгдэхүүний чанар аюулгүй байдлын шалгуурыг боловсронгуй болгох		+	+	+	+	Хүнсний чанар, аюулгүй байдал сайжирч, нянгийн даслаас урьдчилан сэргийлнэ	Эмийн үлдэгдлийг тодорхойлох 2-оос доошгүй аргачлал боловсруулсан байна.	ҮХААЯ, МХЕГ, ТББ
Гурав.Эмийн хүртээмж, хангамж									
Бодлогын чиглэл 3.1.зайлшгүй шаардлагатай эмийн сонголт, эмнэлзүйн удирдамжийг хүн амын өвчлөлийн байдал, хэрэгцээтэй уялдуулах								Хүрэх үр дүн: Эмийг зөв сонгон, эмчилгээ оношлогоонд нэн шаардлагатай эмийн хүртээмж нэмэгдэнэ	

3.1.1.	ЗШЭ-ийн жагсаалтыг эмнэлзүйн удирдамж, зонхилон тохиолдох өвчинтэй уялдуулж шинэчлэн боловсруулах	+			+		Эмийн эмчилгээ эмчилгээний орчин үеийн чиг хандлагад нийцнэ	Зайлшгүй шаардлагатай эмийн жагсаалтыг эмнэлзүйн удирдамжтай уялдуулан 2014, 2017 онд тус тус шинэчлэн баталсан байна.	ЭМЯ, мэргэжлийн зөвлөл
3.1.2.	ЗШЭ-ийн жагсаалтыг хэвлэж хүртээмжтэй түгээх, цахимд байршуулах	+	+		+	+	ЗШЭ-ийн жагсаалтын хүртээмж сайжирч, жагсаалтын хэрэглээ нэмэгдэнэ	ЗШЭ-ийн жагсаалтыг хэвлэн түгээж, цахим сайтад байршуулсан байна.	ЭМЯ, Олон улсын байгууллага, эм нэлгүүд, эрүүл мэндийн байгууллагууд
3.1.3.	Эмийн чиглэлийн мэргэжлийн зөвлөлийн гишүүдийг сонгох шалгуурыг боловсронгуй болгож, бүрэлдэхүүн болон чиг үүргийг тодорхойлох		+				Мэргэжлийн зөвлөлийн үйл ажиллагааны чиглэл тодорхой болно. Эмийн сонголтыг нотолгоонд тулгуурлан хийх нөхцөл бүрдэнэ.	Салбар зөвлөлийн гишүүдийг сонгох шалгуурыг гаргасан байна. Бүрэлдэхүүнийг шалгуурын үндсэн дээр сонгосон байна. Ажиллах чиг үүрэг нь тодорхой болсон байна.	ЭМЯ
3.1.4.	ЗШЭ-ийн жагсаалтын хэрэглээний судалгааг хийх		+	+			ЗШЭ-ийн жагсаалтын хэрэглээ нэмэгдэнэ	Судалгааны тайлан 2016 онд гарсан байна.	АШУУИС, ЭМДГ
Бодлогын чиглэл: 3.2. зайлшгүй шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгсэл, вакцин болон өнчин эм худалдан авах ажиллагааг нэгтгэн зохион байгуулах, эмийн худалдан авалтын үр ашгийг сайжруулах тогтолцоог үе шаттайгаар хэрэгжүүлэх								Хүрэх үр дүн: Улсын төсвийн үр ашиг нэмэгдэнэ	

3.2.1.	Худалдан авах ажиллагааны өнөөгийн тогтолцоо, эмнэлгүүдийн эмийн төсөвт харьцуулсан судалгаа хийж, үнэлэх			+		Эмийн санхүүжилт, төсвийн хуваарилалтын өнөөгийн байдлыг үнэлж, цаашид авах арга хэмжээг тодорхойлно. Эмийн төсвийг нэмэгдүүлэх, төсвийн үр дүнг сайжруулах арга хэмжээг төлөвлөхөд суурь мэдээлэл бий болно	Үнэлгээний тайлан 2016 онд гарсан байна.	ЭМЯ, ЗГХГ-ХААГ
3.2.2.	Эмийн төвлөрсөн худалдан авах ажиллагаанд ашиглах програм хангамжийг боловсруулах		+	+		Худалдан авах ажиллагааны бүртгэл тооцоог үнэн зөв, шуурхай хийх боломж бүрдэнэ	Программ хангамжийг боловсруулж, 2016 оны худалдан авах ажиллагаанд ашиглаж эхэлсэн байна.	ЭМЯ, ХААГ
3.2.3.	Эм, эмнэлгийн хэрэгслийг ерөнхий гэрээгээр худалдан авах ажиллагааг зохицуулах журам боловсруулж, батлуулах		+	+		Өртөг-үр дүнг тооцсон эмийг ерөнхий гэрээгээр худалдан авна, эмнэлгийн тусламжийн чанар сайжирна	Худалдан авах ажиллагааг зохицуулах журмыг Эрүүл мэндийн сайдын тушаалаар 2015 онд баталсан байна.	ЭМЯ, ХААГ
3.2.4.	Эмийн нийлүүлэлтийн гэрээг эмнэлгийн өвчлөл, тухайн үеийн бодит хэрэгцээтэй уялдуулж байгуулах талаар сургалт зохион байгуулах, хяналт тавих		+	+	+	Өртөг-үр дүнг тооцсон эмийг хэрэгцээт тоо хэмжээгээр, боломжийн үнээр, цаг хугацаанд нь нийлүүлэх чадавх нэмэгдэнэ	3-аас доошгүй удаа сургалт зохион байгуулсан байна.	ЭМЯ, сургалтын байгууллага
3.2.5.	ЗШЭ-ийн хангамж, хэрэглээ, үнийн судалгаа хийх			+		ЗШЭ-ийн хангамж, хүртээмжийг нэмэгдүүлэх ажлыг төлөвлөх, гүйцэтгэхэд суурь мэдээлэл болно.	Судалгааны тайлан 2016 онд гарсан байна	ЭМЯ, судалгааны байгууллага

3.2.6.	Эм, эмнэлгийн хэрэгслийг худалдан авах ажиллагааг мэргэжлийн удирдлагаар хангах		+	+	+	+	Чанартай, аюулгүй, эмчилгээний идэвхтэй, өртөг-үр дүнг тооцсон эм худалдан авах боломж нэмэгдэнэ	Нэгдсэн худалдан авалтаар авах эм, эмнэлгийн хэрэгсэл тус бүрд техникийн тодорхойлолт, баримт бичгийг боловсруулсан байна.	ЭМЯ, эмнэлгүүд, ЗГХА-ХААГ, ТББ
Бодлогын чиглэл: 3.3.эмийн түгээлт, хадгалалтын зохистой дадлын шаардлага хангасан эм ханган нийлүүлэх байгууллага, эмийн сангийн зохистой дадлын шаардлага хангасан эмийн сан эм, эмнэлгийн хэрэгслийг хадгалах, олгох үйл ажиллагааг мэргэжлийн түвшинд гүйцэтгэх								Хүрэх үр дүн: Эмийн түгээлт, хадгалалтыг олон улсын түвшинд явуулж, эмийн хангамж, хүртээмж, чанар сайжирна.	
3.3.1.	Эмийн хадгалалт, түгээлтэд тавих ерөнхий шаардлага стандартыг шинэчлэн боловсруулан батлах, хэрэгжилтийг хангах	+	+	+	+	+	Эмийн түгээлт, хадгалалт олон улсын түвшинд хүрч, эмийн чанар, аюулгүй байдал сайжирна.	Эмийн түгээлт, хадгалалтын, зохистой дадлын стандартыг 2014 онд шинэчлэн батална. 2018 онд тусгай зөвшөөрөлтэй эм хангамжийн байгууллага 100% стандартын шаардлага хангасан байна.	ЭМЯ, ЭЗБ, ТББ, ЭХБ
3.3.2.	Эмийн сангийн бүтэц, үйл ажиллагааны стандартыг шинэчлэн боловсруулж, батлах, хэрэгжилтийг хангах		+				Эмийн сангийн үйл ажиллагаа олон улсын жишигт ойртож, эм зүйн тусламжийн чанар сайжирна	Эмийн сангийн бүтэц, үйл ажиллагааны стандартыг шинэчлэн боловсруулж 2015 онд баталсан байна	ЭМЯ, ЭЗБ, ТББ, ЭХБ
3.3.3.	Эм хангамжийн байгууллагад шинэчилсэн стандартын дагуу сургалт явуулах		+		+		Эм хангамжийн байгууллагын өөрийн үйл ажиллагааг олон улсан түвшинд нийцүүлэн явуулах чадавх нэмэгдэнэ	2-оос доошгүй удаа сургалт явуулсан байна.	ЭМЯ, ЭМХТ, АШУУИС, ТББ

3.3.4.	Гадаадын улс орноос ирж буй хандив тусламжийн тайланг гаргаж, нийлүүлсэн эмийн нэр төрөлд дүн шинжилгээ хийх			+		Гадаадын улс орноос ирж буй хандив тусламжийн бодит мэдээлэл бий болно. Хандив тусламжийн зарцуулалтыг сайжруулах арга хэмжээг төлөвлөхөд суурь мэдээлэл бий болно. Цаашид хандив тусламжинд мөрдөх шалгуурыг боловсруулахад суурь мэдээлэл болгон ашиглана	1-ээс доошгүй удаа тайлан гарсан байна	ЭМЯ
Бодлогын чиглэл: 3.4.эм худалдан авах, хадгалах, түгээх, олгох үйл ажиллагаанд хангамжийн удирдлагын мэдээллийн тогтолцоог бэхжүүлэх;							Хүрэх үр дүн: Мэдээллийн хүртээмж нэмэгдэнэ	
3.4.1.	Хангамжийн удирдлагын мэдээллийн тогтолцоог боловсронгуй болгох			+	+	Эм худалдан авах, хадгалах, түгээх, олгох үйл ажиллагааны үнэн зөв, бодит мэдээллийг олж авах, үйл ажиллагааг зөв зохион байгуулах боломж нэмэгдэнэ	Хангамжийн удирдлагын мэдээллийн тогтолцоог 2017 онд нэвтрүүлсэн байна	Засгийн газар, эрүүл мэндийн байгууллагууд
3.4.2.	Хангамжийн удирдлагын мэдээллийн тогтолцооны сургалтыг явуулах				+	Хангамжийн удирдлагын тогтолцоог үр дүнтэй нэвтрүүлэх, хэрэгжүүлэх боломж, чадавх нэмэгдэнэ	2-оос доошгүй удаа сургалт явуулсан байна.	ЭМЯ, ТББ
Бодлогын чиглэл: 3.5.эмийн сангийн байршлыг хүн амын нягтрал, суурьшил болон газарзүйн байршилтай уялдуулах							Хүрэх үр дүн: Эмийн хүртээмж сайжирна	

3.5.1.	Хүн амын байршил, эмийн сангийн хоорондын зайг уялдуулан шаардлагатай газарт эмийн сан байгуулахад дэмжлэг үзүүлэх		+	+	+	+	Эмийн хүртээмж нэмэгдэж, хүн амыг чанартай, аюулгүй, эмчилгээний идэвхтэй эмээр тасралтгүй, жигд хангах боломж нэмэгдэнэ	Алслагдсан баг, дүүрэгт эрүүл мэндийн даатгалаар үйлчлэх эмийн сан 2013 оны үзүүлэлттэй харьцуулахад 2018 онд 20%-иар нэмэгдсэн байна.	ЭМЯ, ЭЗБ, ЭМГ, ЭМДГ
3.5.2.	Эрүүл мэндийн даатгалаар үйлчлэх эмийн санг сонгох журмыг шинэчлэх, мөрдөх				+		Эрүүл мэндийн даатгалын хүртээмж нэмэгдэнэ	Эрүүл мэндийн даатгалаар үйлчлэх эмийн сангийн тоо, байршлыг тогтоох журмыг 2017 онд шинэчлэн баталсан байна.	ЭМДГ, ЭМЯ, ЭМГ
3.5.3.	Эмийн эргэлтийн санг сумын эрүүл мэндийн төвд нэгтгэн орон нутгийн хүн амыг шаардлагатай эмээр хангах, үйлчлэх			+	+		Сум, орон нутгийн эм, эмнэлгийн хэрэгслийн хангамж зохицуулагдана.	2017 онд эмийн эргэлтийн сан сумын эрүүл мэндийн төвтэй нэгдсэн байна	ЭМЯ, СЯ, нутгийн захиргааны байгууллагууд
Бодлогын чиглэл: 3.6.эмийн үндэсний үйлдвэрлэлд шинэ техник, технологи, тоног төхөөрөмж нэвтрүүлэхэд, импортыг орлох зайлшгүй шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгсэл, уламжлалт эмийг дотооддоо үйлдвэрлэхэд болон худалдан авах ажиллагаанд дэмжлэг үзүүлэх								Хүрэх үр дүн: Эмийн үндэсний үйлдвэрлэлийн чадавх сайжирна	
3.6.1.	ЗШЭ-ийн үйлдвэрлэлийг нэмэгдүүлэхэд төрөөс дэмжлэг үзүүлэх		+	+	+	+	Эх орны эмийн үйлдвэрлэл олон улсын түвшинд ойртоно, хэрэгцээт эмийг үйлдвэрлэх чадавх нэмэгдэнэ, импортоос хараат байдал буурах боломж нэмэгдэнэ	Эмийн үндэсний үйлдвэрлэлд шинэ техник, технологи, тоног төхөөрөмж нэвтрүүлэхэд үзүүлэх дэмжлэг болон ЗШЭ-ийн үйлдвэрлэл 2013 онтой харьцуулахад 2018 онд 15% иар өссөн байна.	Засгийн газар, эм хангамжийн байгууллага

3.6.2.	Дотоодын эмийн үйлдвэрүүдийн нэгдсэн цогцолбор байгуулах боломжийг судлах			+	+	Эх орны эмийн үйлдвэрийн хөгжлийн чиг хандлага тодорхойлогдоно, эмийн үйлдвэрлэлд ахиц дэвшил гарна.	Зураг төсөл 2016 онд гарсан байх	Эм хангамжийн байгууллагууд, Эм холбоо
Бодлогын чиглэл:							Хүрэх үр дүн:	
3.7.зонхилон тохиолдох, санхүүгийн дарамт үүсгэх өвчин эмгэгийн эмчилгээ, оношилгоо болон ядуу, эмзэг бүлгийн хүн амд шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгслийн зардлыг улсын төсөв болон эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлэхэд төрөөс дэмжлэг үзүүлэх							Зонхилон тохиолдох, санхүүгийн дарамт үүсгэх өвчин эмгэгийн эмчилгээ, оношилгоо болон ядуу, эмзэг бүлгийн хүн амд шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгслийн эмийн санхүүжилт сайжирна.	
3.7.1.	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлэх зонхилон тохиолдох болон санхүүгийн дарамт үүсгэх өвчин эмгэгийн эмчилгээ, оношилгоонд шаардагдах эм, эмнэлгийн хэрэгслийн хэрэглээний судалгаа хийж, хэрэгцээг тодорхойлох			+	+	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлэх зонхилон тохиолдох болон санхүүгийн дарамт үүсгэх өвчин эмгэгийн эмчилгээ, оношилгоонд шаардагдах эм, эмнэлгийн хэрэгслийн жагсаалт гаргах, хангах үйл ажиллагааг төлөвлөх, зохион байгуулахад суурь мэдээлэл бий болно	Судалгааны тайлан 2017 онд гарсан байна.	ЭМЯ, ЭМДГ, ЭМГ, ТББ, АШУУИС

3.7.2.	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлэх зонхилон тохиолдох болон санхүүгийн дарамт үүсгэх өвчин эмгэгийн эмчилгээ, оношилгоонд шаардагдах эм, эмнэлгийн хэрэгслийн жагсаалт гаргах, цахимд байршуулах				+	ЭМД-ийг зөв, хүртээмжтэй, үр ашигтай, ил тод, хариуцлагатай зарцуулах боломж нэмэгдэнэ	ЭМД-ын сангаас санхүүжүүлэх зонхилон тохиолдох болон санхүүгийн дарамт үүсгэх өвчин эмгэгийн эмчилгээ, оношилгоонд шаардагдах эм, эмнэлгийн хэрэгслийн жагсаалтыг 2017 онд гаргаж, цахимд байршуулсан байна	ЭМЯ, ЭМДГ, эрүүл мэндийн байгууллагууд, АШУУИС
3.7.3.	"Нийгмийн халамжид хамрагдагсдад эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх журам"-ын хэрэгжилтийг хангах			+	+	Ядуу, эмзэг бүлгийн хүн амд үзүүлэх эрүүл мэндийн тусламжийн чанар, хүртээмж сайжирна.	"Нийгмийн халамжид хамрагдагсдад эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх журам"-ыг хэрэгжүүлэх эмийн төсвийг 2016-2018 оны улсын төсөвт тусгасан байна.	НХХЯ, СЯ, ЭМЯ
Бодлогын чиглэл:							Хүрэх үр дүн:	
3.8.мал, амьтны гоц халдварт, халдварт ба шимэгчит өвчнөөс сэргийлэх, эмчлэхэд шаардагдах зардлыг улсын төсвөөс санхүүжүүлэх							Мал, амьтны гоц халдварт, халдварт ба шимэгчит өвчинд хэрэглэх эмийн хангамж сайжирна	
3.8.1.	Мал, амьтны гоц халдварт, халдварт ба шимэгчит өвчнөөс сэргийлэх, эмчлэхэд шаардагдах эмийн хэрэглээний судалгаа хийж, хэрэгцээг тодорхойлох			+		Мал, амьтны гоц халдварт, халдварт ба шимэгчит өвчнөөс сэргийлэх, эмчлэхэд шаардагдах эм, эмнэлгийн хэрэгслийн жагсаалт гаргах, хангах үйл ажиллагааг төлөвлөх, зохион байгуулахад суурь мэдээлэл бий болно	Судалгааны 2016 онд гарсан тайлан	ҮХААЯ

3.8.2.	Мал, амьтны гоц халдварт, халдварт ба шимэгчит өвчнөөс сэргийлэх, эмчлэхэд хэрэглэх эм, эмнэлгийн хэрэгслийн санхүүжилтийг улсын төсөвт суулгах	+	+	+	+	+	Мал, амьтны гоц халдварт, халдварт ба шимэгчит өвчнөөс сэргийлэх, эмчлэхэд хэрэглэх эм, эмнэлгийн хэрэгслийн санхүүжилт тодорхой болсон байна.	Санхүүжилт улсын төсөвт жил бүр суусан байна	ҮХААЯ
Дөрөв. Эм худалдан авах боломж									
Бодлогын чиглэл: 4.1.ерөнхий нэршлийн эмийн хэрэглээг дэмжих замаар эмийн үнийн мэдээллийг сайжруулах								Хүрэх үр дүн: Ерөнхий нэршлийн эмийн хэрэглээ төлөвшиж, эмийн үнэ буурна	
4.1.1.	Ерөнхий нэршлийн эмийг орлуулан хэрэглэх зарчмыг холбогдох эрх зүйн баримт бичигт тусгаж, хэрэгжилтийг хангах		+	+			Ерөнхий нэршлийн эмийн хэрэглээ нэмэгдэнэ, хэрэглэгчид боломжийн үнээр эмчилгээний идэвхтэй, чанартай, аюулгүй эм худалдан авах нөхцөл нэмэгдэнэ	Худалдааны нэршил бүхий эмийг ерөнхий нэршлийн эмээр орлуулан хэрэглэх зарчим холбогдох эрх зүйн баримт бичигт туссан байна.	ЭМЯ
4.1.2.	Эмийн үнийн мэдээний санг бий болгох			+	+	+	Мэдээллийн хүртээмж нэмэгдэнэ. Хүн амыг боломжийн үнэтэй эмээр хангах боломж нэмэгдэнэ	Мэдээний сан 2016 онд бий болсон байна.	ЭМЯ, эм хангамжийн байгууллагууд
4.1.3.	Эмийн үнийг шошгонд байрлуулах эрх зүйн орчинг бүрдүүлж, хэрэгжүүлэх		+	+	+	+	Эмийн үнийг үндэслэлгүй тогтоох, үнийг нэмэх боломж буурна. Эмийн үнийн мэдээллийг ил тод байлгах эрх зүйн орчин бүрдэнэ	Эмийн үнийг шошгонд байрлуулах талаар холбогдох эрх зүйн баримт бичигт 2015 онд тусгасан байна	ЭМЯ, ЭХБ

4.1.4.	Зайлшгүй шаардлагатай эмийн үнийн зохицуулалтын талаар холбогдох эрх зүйн баримт бичигт тусгах		+				Зайлшгүй шаардлагатай эмийн үнэ буурч бүсийн түвшинд ойртоно, эм худалдан авах боломж нэмэгдэнэ	Зайлшгүй шаардлагатай эмийн үнийн зохицуулалтын талаар холбогдох эрх зүйн баримт 2015 онд тусгасан байна.	ЭМЯ
4.1.5.	Зайлшгүй шаардлагатай эмийн үнийг тогтоох			+	+	+	Эмийн үнийг үндэслэлгүй тогтоох боломж буурна. Хүн амын эм худалдан авах боломж нэмэгдэнэ	Зайлшгүй шаардлагатай эмийн үнийг 2016 оноос тогтоож эхэлсэн байна	ЗГ, ЭМЯ
Тав. Эмийн зохицуулалт, засаглал									
Бодлогын чиглэл: 5.1.эмийн зохицуулалт, хяналтын үйл ажиллагааг төрийн зүгээс нэгдсэн зохицуулалтаар хангаж, бэхжүүлэх								Хүрэх үр дүн: Эмийн зохицуулалт сайжирна	
5.1.1.	Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай болон бусад холбогдох хууль, эрх зүйн баримт бичигт өөрчлөлт оруулж ЭЗА байгуулах эрх зүйн орчинг бүрдүүлэх		+	+			Эмийн зохицуулалт хүчирхэгжиж, хүн амыг чанартай, аюулгүй, эмчилгээний идэвхтэй эмээр хангана, эм зүйн тусламжийн чанар сайжирна.	Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийг 2015 онд шинэчлэн боловсруулсан байна.	ЗГ, ЭМЯ
5.1.2.	ЭЗБ-ын дүрэм, бүтцийг ЗГ-ын тогтоолоор батлах, ЭЗБ-г байгуулж, үйл ажиллагааг тогтмолжуулах			+			Эмийн зохицуулалтын эрх бүхий байгууллагын үйл ажиллагаа сайжирснаар эмийн аюулгүй байдлын дэглэм бэхжиж, олон улсын түвшинд хүрнэ.	ЭЗБ-ын дүрэм, бүтцийг ЗГ-ын тогтоолоор 2016 онд баталсан байна	ЗГ, ЭМЯ

5.1.3.	ДЭМБ-ын сертификатын схем, ОУ-ын болон бүсийн төвд ЭЗБ-ыг бүртгүүлж хамтын ажиллагааг бэхжүүлэх				+	+	Эмийн зохицуулалтын үйл ажиллагаа олон улсын түвшинд хүрнэ, ЭЗБ-ын байгууллагын нэр хүнд нэмэгдэнэ. Монгол улсад үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг олон улсад хүлээн зөвшөөрөх боломж нэмэгдэнэ	ЭЗБ-ыг ДЭМБ-ын сертификатын схем, ОУ-ын болон бүсийн төвд 2017 онд бүртгүүлсэн байна.	ЭЗБ
5.1.4.	ЭЗБ-ын дунд хугацааны стратеги төлөвлөгөөг боловсруулах, ЭЗБ ба төрийн бусад байгууллага, хувийн хэвшил, ТББ-ын хамтын ажиллагааны чиглэлийг тодорхойлж үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгах				+		Эмийн зохицуулалтад оролцогч талуудын гүйцэтгэх оролцоо нэмэгдэнэ. Эмийн зохицуулалтын үйл ажиллагааны үр дүн сайжирна.	Эмийн зохицуулалтад төрийн ба төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн гүйцэтгэх үүрэг хариуцлагыг тодорхойлсон стратегийг 2016 онд боловсруулсан байна	ЭЗБ, ТББ, ЭХБ
5.1.5.	Эм зүйн салбарын үйл ажиллагаанд хэрэглэх нэр томъёоны тайлбарыг боловсруулах				+	+	Эм зүйн салбарын үйл ажиллагаанд хэрэглэх нэр томъёо тодорхой болно.	Эм зүйн салбарын үйл ажиллагаанд хэрэглэх нэр томъёоны тайлбарыг 2017 онд гаргасан байна.	ЭМЯ, ЭЗБ, АШУУИС, ТББ
Бодлогын чиглэл: 5.2.эм зүйн салбарт сайн засаглалыг бэхжүүлэх								Хүрэх үр дүн: Эм зүйн салбарт ил тод, хариуцлагатай байдал төлөвшиж, мэдээллийн хүртээмж сайжирна	
5.2.1.	ЭЗБ-ын үйл ажиллагааг ОУ-ын стандартын дагуу үнэлэх					+	Эмийн зохицуулалтын үйл ажиллагаа олон улсын жишигт хүрэх боломж бүрдэнэ.	ISO 17020-ийн дагуу үнэлсэн тайлан 2018 онд гарсан байна.	ЭЗБ, ДЭМБ

5.2.2.	Эм зүйн салбарын үйл ажиллагааны ил тод байдлыг үнэлж мэдээлэх, хариуцлагыг дээшлүүлэх тогтолцоог бий болгох			+			Эм зүйн салбарын үйл ажиллагаанд ил тод, хариуцлагатай байдал төлөвшинэ. Шийдвэрийг хуулийн дагуу, бүх оролцогч талуудад тэгш шударга гаргах нөхцөл бүрдэнэ. Төсвийн хөрөнгийг үр ашигтай, шударга зарцуулна.	Үнэлгээний тайлан 2016 онд гарсан, түгээсэн байна. Эм зүйн салбарын үйл ажиллагааны зураглалыг гарган түгээсэн байна. Үйлчлүүлэгчээс шуурхай мэдээлэл хүлээн авах цахим хуудас, төлбөргүй утсыг бий болгосон байна.	ЭМЯ, ЭЗБ, ТББ
5.2.3.	Эм зүйн салбарын ёс зүйн дүрмийг боловсруулж, түгээх, мөрдөх			+	+	+	Эм зүйн салбарын үйл ажиллагааг ёс зүйтэй явуулах, авлигыг бууруулах, авлигаас сэргийлэх боломж нэмэгдэнэ	Эм зүйн салбарын ёс зүйн дүрмийг эрүүл мэндийн сайдын тушаалаар 2016 онд батлуулж, түгээсэн байна.	ЭМЯ, ТББ, ЭХБ
5.2.4.	Эм зүйн салбарын үндсэн үйл ажиллагааны статистик үзүүлэлтэд тулгуурлан эм зүйн салбарын нэгдсэн бодит мэдээллийг гаргаж хэвших		+	+	+	+	Эм зүйн салбарын үйл ажиллагааны ил тод байдлыг хангана, эм зүйн салбарын үйл ажиллагааны мэдээллийг бий болгоно. Эм зүйн салбарт хэрэгжүүлэх үйл ажиллагааг төлөвлөх, зохион байгуулахад суурь мэдээлэл бий болно.	Эм зүйн салбарын жилийн үзүүлэлтийг жил бүр нэгтгэж 4 удаа хэвлэсэн байна.	ЭМЯ, ЭМХТ, ЭЗБ, МХЕГ, ЭХБ
5.2.5.	Эмийн сайн засаглалыг сайжруулах зорилгоор холбогдох байгууллагатай хамтран ажиллах		+	+	+	+	Салбар дундын хамтын ажиллагаа сайжирна. Авлига буурна, шударга, ил тод, хариуцлагатай байдал бэхжинэ.	2-оос доошгүй байгууллагатай хамтран ажиллсан байна.	ЭМЯ, ЭЗБ, холбогдох бусад байгууллага
Зургаа. Хүний нөөц									
Бодлогын чиглэл: 6.1.эм зүйн салбарын хүний нөөцийг хөгжүүлэх стратегийг сургалтын байгууллага, мэргэжлийн нийгэмлэг, холбоотой хамтран боловсруулах, хэрэгжүүлэх үйл ажиллагааг удирдан зохион байгуулах								Хүрэх үр дүн: Эм зүйн салбарын хүний нөөцийн чадавх сайжирна	

6.1.1.	Хүний нөөцийг хөгжүүлэх стратегийг батлан оролцогч талуудад ил тод мэдээлэх				+		Эм зүйн мэргэжилтний мэдлэг, ур чадвар сайжирна, эмнэлгийн тусламжийн чанар дээшилнэ, эм зүйн мэргэжилтний үнэлэмж нэмэгдэнэ	Хүний нөөцийг хөгжүүлэх стратегийг 2017 онд баталсан байна.	ЭМЯ, ЭМХТ, сургалтын байгуулага
6.1.2.	Эм зүйн мэргэжлээр төгсөгч болон мэргэшсэн хүний нөөцийн бүртгэлийн санг бий болгох, тогтмолжуулах			+	+	+	Эм зүйн мэргэжлээр төгсөгч болон мэргэшсэн хүний нөөцийн мэдээлэл бий болно. Хүний нөөцийг төлөвлөхөд суурь мэдээлэл бий болно	Эм зүйн мэргэжлээр төгсөгч болон мэргэшсэн хүний нөөцийн бүртгэлийн санг 2017 онд бий болгосон байна	ЭЗБ, ТББ, ЭХБ
6.1.3.	Эмийн мэргэжилтний тасралтгүй сургалтын төрөл, тоо, чанарыг үнэлж, бүртгэл хөтлөх		+	+	+	+	Эмийн мэргэжилтэнд зориулан явуулсан тасралтгүй сургалтын бүртгэл бий болно. Хүний нөөцийг хөгжүүлэх үйл ажиллагааг зохион байгуулахад суурь мэдээлэл бий болно	Эмийн мэргэжилтний тасралтгүй сургалтын төрөл, тоо, чанарыг нэгтгэн дүгнэж бүртгэлийг 2015 оноос хөтөлсөн байна	ЭМХТ, ТББ
Долоо. Судалгаа, шинжилгээ									
Бодлогын чиглэл: 7.1.эмийн талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэхэд тулгамдаж буй асуудлыг тодорхойлон шийдвэрлэж, гүйцэтгэлийг үнэлэх судалгаа хийх								Хүрэх үр дүн: Эмийн талаар баримтлах бодлогын хэрэгжилт сайжирна	
7.1.1.	Төрөөс эмийн талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэхэд тулгамдаж буй асуудал, түүнийг шийдвэрлэх арга замыг тодорхойлох			+			Эм зүйн салбарын үйл ажиллагаанд тулгарч буй асуудал тодорхой болно. Бодлогыг хэрэгжүүлэхэд тулгарч буй асуудлыг шийдвэрлэхэд суурь мэдээлэл бий болно	Төрөөс эмийн талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэхэд тулгамдаж буй асуудлыг 2016 онд тодорхойлсон байна.	ЭМЯ, ЭЗБ, ТББ, МХЕГ

7.1.2.	Судалгаа, шинжилгээний ажлын үр дүнгийн нэгдсэн санг бий болгож, нээлттэй мэдээлэх		+	+	+	+	Судалгаа шинжилгээний ажлын үр дүнг ашиглах боломж сайжирна, салбарын болон салбар дундын хамтын ажиллагаа сайжирна, мэдээллийн хүртээмж нэмэгдэх боломж бүрдэнэ	Судалгаа, шинжилгээний ажлын үр дүнгийн нэгдсэн санг 2015 оноос бий болгож эхэлсэн байна	ЭМЯ, ЭЗБ, АШУУИС
7.1.3.	Дэмжлэг үзүүлэхээр тодорхойлсон технологийг нэвтрүүлэх, эм, эмнэлгийн хэрэгслийг бүтээх судалгааны санхүүжилтийг шинжлэх ухаан, технологийн сангаас дэмжих		+	+	+	+	Эх орны эмийн үйлдвэрийн технологи сайжирч олон улсын түвшинд ойртох боломж нэмэгдэнэ. Шинэ технологийг нэвтрүүлнэ. Зонхилон тохиолдох өвчин эмгэгийн эмчилгээнд хэрэглэх эмчилгээний идэвхтэй, чанартай, аюулгүй эмийн тоо нэмэгдэнэ, импортын хараат байдал буурна	Дэмжлэг үзүүлэхээр тодорхойлсон технологийг нэвтрүүлэх; эм, эмнэлгийн хэрэгслийг бүтээх судалгаанд олгосон санхүүжилтийн дүн 2014 оны үзүүлэлттэй харьцуулахад 2018 онд 10%-иар өссөн байна.	ЭМЯ, ШУТС
7.1.4.	Эм зүйн салбарын судалгаа шинжилгээний тэргүүлэх чиглэлийг тогтоох		+				Судалгаа шинжилгээнд зарцуулах нөөцийг зөв хуваарилах боломж нэмэгдэнэ. Эм зүйн салбарын хөгжил түргэснэ. Эм зүйн салбарын судалгаа шинжилгээний түвшин сайжирч, олон улсын түвшинд ойртоно	Эм зүйн салбарын судалгаа шинжилгээний тэргүүлэх чиглэлийг 2015 онд тогтоосон байна.	ШУА, судалгааны байгууллага
Найм. Бодлогын хэрэгжилтийн хяналт, үнэлгээ									
Бодлогын чиглэл: 8.1.эмийн талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэхтэй холбогдуулан эмзүйн салбарын эрх зүйн орчныг боловсронгуй болгох, үнэлэх								Хүрэх үр дүн: Бодлогын хэрэгжилт сайжирна.	
8.1.1.	Бодлогын хэрэгжилтэнд хяналт, шинжилгээ хийх		+	+	+	+	Төрөөс эмийн талаар баримтлах бодлогын хэрэгжилтийг хангана. Бодлогыг амжилттай хэрэгжүүлэх ажлыг төлөвлөх, зохион байгуулахад суурь мэдээлэл бий болно	Хяналт, шинжилгээний тайлан 4 удаа гарсан байна.	ЭМЯ

8.1.2.	Төрөөс эмийн талаар баримтлах бодлогын явцын хэлэлцүүлэг зохион байгуулах		+			Бодлогыг хэрэгжүүлэхэд цаашид авах арга хэмжээний талаар зөвлөмж гарна, хэрэгжилтийг сайжруулах арга замыг тодорхойлно	2015 онд хэлэлцүүлэг зохион байгуулсан байна.	ЭМЯ, ТББ, сургалтын байгууллага
8.1.3.	Төрөөс эмийн талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэх төлөвлөгөөг оролцогч талуудад түгээх, мэдээлэх		+			Төрөөс эмийн талаар баримтлах бодлогыг үр дүнтэй, амжилттай хэрэгжүүлэх нөхцөл бүрдэнэ. Бодлогыг хэрэгжүүлэхэд оролцогч талуудын үүрэг хариуцлага, хамтын ажиллагаа нэмэгдэнэ	Төрөөс эмийн талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэх төлөвлөгөөг баталж, оролцогч талуудад 2015 онд түгээсэн байна	ЭМЯ, ТББ
8.1.4.	Бодлогын хэрэгжилтийн үнэлгээ хийх, тайлагнах, үнэлгээний тайланг түгээх				+	Төрөөс эмийн талаар баримтлах бодлогын хэрэгжилтийг үнэлж, дараагийн бодлого боловсруулахад ашиглах суурь мэдээлэл бий болно	Үнэлгээний тайлан 2018 онд гарсан байна.	ЭМЯ
8.1.5.	Төрөөс эмийн талаар баримтлах бодлогын чуулганыг зохион байгуулах, төрөөс эмийн талаар баримтлах бодлогыг шинэчлэн боловсруулахад тусгах санал, зөвлөмжийг гаргах				+	Төрөөс эмийн талаар баримтлах бодлогын хэрэгжилтийг үр дүнг хэлэлцэнэ. Дараагийн бодлогод тусгах санал зөвлөмж гарна.	Төрөөс эмийн талаар баримтлах бодлогын чуулганыг 2018 онд зохион байгуулсан байна. Төрөөс эмийн талаар баримтлах бодлогыг шинэчлэн боловсруулахад тусгах санал, зөвлөмж гарсан байна.	ЭМЯ